

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2024 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:erdeneb@audit.gov.mn">erdeneb@audit.gov.mn</a> Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a> “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170 Цахим хаяг: <a href="mailto:dalaivan.orkhon@gmail.com">dalaivan.orkhon@gmail.com</a> Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99921600 Цахим хаяг: <a href="mailto:dalaivan.orkhon@gmail.com">dalaivan.orkhon@gmail.com</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 188

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН 2 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Д.МӨНХЖАРГАЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн ба улсын төсвөөс 832,774.9 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 131,824.6 мянган төгрөгийн нийт 964,599.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх онтой харьцуулахад 253,766.1 төгрөгөөр буюу 35.6 хувиар өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 63,930.9 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

#### Аудитын гол асуудал

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжүүлэх болсноор сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 8 болж зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний

006020434

бусад зардлаас зарцуулах болсон байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зургаан зорилтын хүрээнд дөчин хоёр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 85.0 хувийн биелэлтэйгээр дүгнэгдсэн байна.

Тус цэцэрлэг нь тайлангийн хугацааны эцэст бараа материалын дансанд 16,289.5 мянган төгрөгийн хоол хүнсний материал үлдэгдэлтэй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тус цэцэрлэгт Булган аймгийн Засаг даргын тамгын газраас 3-н нэр төрлийн 11.3 ширхэг 2,472.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөрийг хүлээн авсан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

<b>Дансны код</b>	<b>Балансын үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>82,550,195.01</u></b>	<b><u>164,240,485.80</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	11,592,131.40	75,523,123.62
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	11,592,131.40	75,523,123.62
31211	Төрийн сангийн харилцах	11,592,131.40	75,523,123.62
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	70,847,527.68	88,717,362.18
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	43,705.00	72,640.00
35130	Эм боох материал	43,705.00	72,640.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	70,803,822.68	88,644,722.18
35410	Бичиг хэргийн материал	1,442,500.00	1,331,500.00
35420	Аж ахуйн материал	15,992,977.68	31,627,774.68
35430	Сэлбэг хэрэгсэл	1,154,900.00	1,154,900.00
35460	Хүнсний материал	12,878,927.50	16,289,530.00
35470	Бусад хангамжийн материал	39,326,017.50	38,241,017.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,318,925,238.80</u></b>	<b><u>1,286,022,677.16</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,318,925,238.80	1,286,022,677.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,282,628,989.02	1,250,256,427.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,340,263,493.00	1,340,263,493.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(103,122,288.12)	(125,460,012.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,481,141.00	42,660,231.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,610,491.12)	(27,272,309.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,018,967.00	39,663,367.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,033,728.84)	(20,763,395.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,987,750.00	2,987,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,666,119.90)	(1,987,752.66)
39217	Ном	310,266.00	165,057.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	36,296,249.78	35,766,249.74
39301	Програм хангамж	2,380,000.00	2,080,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,253,750.22)	(1,483,750.26)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,170,000.00	35,170,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,401,475,433.81</u></b>	<b><u>1,450,263,162.96</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>6,126,140.13</u></b>	<b><u>883,150.49</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,126,140.13	883,150.49
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,126,140.13	883,150.49
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,066,789.40	0.49
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	883,150.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	708,150.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	175,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,395,349,293.68</u></b>	<b><u>1,449,380,012.47</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,395,349,293.68	1,449,380,012.47

Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	241,344,798.00	241,344,798.00
51101	Өмч: - төрийн	241,344,798.00	241,344,798.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	927,876,917.16	981,907,635.95
51210	Өмнөх үеийн үр дүн	927,876,917.16	927,876,917.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	54,030,718.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,127,578.52	226,127,578.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,401,475,433.81</b>	<b>1,450,263,162.96</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>720,241,160.00</b>	<b>1,003,630,567.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		7,627,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	103,500.00	31,404,067.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>710,833,400.00</b>	<b>964,599,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	594,592,900.00	832,774,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	594,592,900.00	832,774,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	116,240,500.00	131,824,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,240,500.00	131,824,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>734,080,514.60</b>	<b>949,454,639.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>734,080,514.60</b>	<b>949,454,639.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	725,155,340.60	948,959,894.25
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	448,523,177.56	577,271,637.65
210101	Үндсэн цалин	327,381,424.80	395,651,728.04
210102	Нэмэгдэл	92,285,129.00	152,707,129.24
210104	Урамшуулал	28,856,623.76	28,912,780.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,918,471.84	73,311,384.33
210201	Тэтгэврийн даатгал	39,596,572.70	50,689,276.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,643,482.05	5,965,119.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,691,635.63	4,679,635.55
210204	Ажилгүйдлийн даатгал	899,525.36	1,088,904.91
210205	Эрүүл мэндийн даатгал	9,087,256.10	10,888,448.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	95,923,889.40	107,263,291.64
210301	Гэрэл, цахилгаан	9,094,464.00	9,458,052.02
210302	Түлш, халаалт	78,087,260.80	85,390,419.62
210303	Цэвэр, бохир ус	8,742,164.60	12,414,820.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	60,430,294.00	86,861,453.99
210502	Хоол, хүнс	60,333,759.00	86,861,453.99
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	180,000.00	17,999,774.00
210604	Урсгал засвар	-	17,999,774.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,227,800.00	1,792,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,227,800.00	1,792,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	56,088,222.60	84,460,252.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,837,760.00	37,984,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,823,650.00	5,161,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	39,426,812.60	41,314,342.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,925,174.00	494,744.96

Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	174.00	494,744.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	174.00	494,744.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(13,839,354.60)</b>	<b>54,175,927.79</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	145,209.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	145,209.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(145,209.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(13,839,354.60)</b>	<b>54,030,718.79</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>710,833,400.00</b>	<b>964,599,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>710,833,400.00</b>	<b>964,599,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	594,592,900.00	832,774,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	594,592,900.00	832,774,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	116,240,500.00	131,824,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,240,500.00	131,824,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>699,241,268.60</b>	<b>899,738,517.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>699,241,268.60</b>	<b>899,738,517.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>690,316,094.60</b>	<b>899,243,772.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	448,574,362.76	578,357,052.45
210101	Үндсэн цалин	327,432,610.00	396,737,142.84
210102	Нэмэгдэл	92,285,129.00	152,707,129.24
210104	Урамшуулал	28,856,623.76	28,912,780.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,918,471.84	73,311,384.33
210201	Тэтгэврийн даатгал	39,596,572.70	50,689,276.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,643,482.05	5,965,119.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,691,635.63	4,679,635.55
210204	Ажилгүйдлийн даатгал	899,525.36	1,088,904.91
210205	Эрүүл мэндийн даатгал	9,087,256.10	10,888,448.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	89,857,100.00	113,330,081.04
210301	Гэрэл, цахилгаан	9,094,464.00	9,458,052.02
210302	Түлш, халаалт	72,020,471.40	91,457,209.02
210303	Цэвэр, бохир ус	8,742,164.60	12,414,820.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	69,054,700.00	90,272,056.00
210502	Хоол, хүнс	69,054,700.00	90,272,056.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	17,999,774.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	17,999,774.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,227,800.00	1,792,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,227,800.00	1,792,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,200,260.00	24,181,325.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,420,260.00	18,805,125.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,780,000.00	5,376,200.00

Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,925,174.00	494,744.96
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	174.00	494,744.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	174.00	494,744.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,592,131.40	64,860,982.22
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	929,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	929,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	929,990.00
222001	Тоног төхөөрөмж	-	369,990.00
223001	Бусад хөрөнгө	-	560,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(929,990.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,592,131.40	63,930,992.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,592,131.40
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,592,131.40	75,523,123.62

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
Тайлант үеийн үр дүн	241,354,798.00	226,127,578.52	927,876,917.16	1,395,359,293.68
2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	241,344,798.00	226,127,578.52	927,876,917.16	1,395,349,293.68
2023 оны 1-р сарын 1-ээр үлдэгдэл	241,344,798.00	226,127,578.52	927,876,917.16	1,395,349,293.68
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	241,344,798.00	226,127,578.52	927,876,917.16	1,395,349,293.68
Тайлант үеийн үр дүн	-	-	54,030,718.79	54,030,718.79
2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	241,344,798.00	226,127,578.52	981,907,635.95	1,449,380,012.47

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
4	<b>71801 - СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ</b>					
4	1220	Тусламжийн орлого	131,824,600.00	131,824,600.00		100
5	122005	Төсвөөс санхүүжих	131,824,600.00	131,824,600.00		100
6	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,824,600.00	113,330,081.04	494,518.96	99.57
7	210301	Гэрэл, цахилгаан	9,867,300.00	9,458,052.02	409,247.98	95.85
8	210302	Түлш, халаалт	91,457,300.00	91,457,209.02	90.98	100
9	210303	Цэвэр, бохир ус	12,500,000.00	12,414,820.00	85,180.00	99.32
10	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,000,000.00	17,999,774.00	226	100
11	210604	Урсгал засвар	18,000,000.00	17,999,774.00	226	100

Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

12	261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		494,744.96	-494,744.96	
13	<b>81605 - ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ</b>					
13	1220	Тусламжийн орлого	2,688,100.00	2,688,100.00		100
14	122005	Төсвөөс санхүүжих	2,688,100.00	2,688,100.00		100
15	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,688,100.00	2,586,500.00	101,600.00	96.22
16	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,688,100.00	2,586,500.00	101,600.00	96.22
17	<b>81807 - ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ</b>					
17	1220	Тусламжийн орлого	93,434,100.00	93,434,100.00		100
18	122005	Төсвөөс санхүүжих	93,434,100.00	93,434,100.00		100
19	2105	Норматив зардал	93,434,100.00	90,272,056.00	3,162,044.00	96.62
20	210502	Хоол, хүнс	93,434,100.00	90,272,056.00	3,162,044.00	96.62
21	<b>81816 - ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР</b>					
21	1220	Тусламжийн орлого	4,231,300.00	4,231,300.00		100
22	122005	Төсвөөс санхүүжих	4,231,300.00	4,231,300.00		100
23	2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,221,990.00	-4,221,990.00	
24	210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,221,990.00	-4,221,990.00	
25	<b>81823 - БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ АЖИЛЧДЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ</b>					
25	1220	Тусламжийн орлого	2,688,100.00	2,688,100.00		100
26	122005	Төсвөөс санхүүжих	2,688,100.00	2,688,100.00		100
27	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,688,100.00	2,688,100.00		100
28	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,688,100.00	2,688,100.00		100
29	<b>81834 - БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>					
29	1220	Тусламжийн орлого	595,720,100.00	595,720,100.00		100
30	122005	Төсвөөс санхүүжих	595,720,100.00	595,720,100.00		100
31	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,419,000.00	493,303,082.31	21,115,917.69	95.9
32	210101	Үндсэн цалин	343,114,300.00	337,305,152.89	5,809,147.11	98.31
33	210102	Нэмэгдэл	157,628,100.00	134,150,904.79	23,477,195.21	85.11
34	210104	Урамшуулал	13,676,600.00	21,847,024.63	-8,170,424.63	159.74
35	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,477,500.00	62,766,500.07	5,710,999.93	91.66
36	210201	Тэтгэврийн даатгал	46,564,500.00	43,174,525.18	3,389,974.82	92.72
37	210202	Тэтгэмжийн даатгал	5,478,400.00	5,083,361.58	395,038.42	92.79
38	210203	ҮОМШӨ-ний даатгал	4,381,800.00	3,987,449.38	394,350.62	91
39	210204	Ажилгүйдлийн даатгал	1,095,900.00	956,505.84	139,394.16	87.28
40	210205	Эрүүл мэндийн даатгал	10,956,900.00	9,564,658.09	1,392,241.91	87.29

Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

41	<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,792,100.00	1,792,100.00		100
42	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,792,100.00	1,792,100.00		100
43	<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	16,079,400.00	15,614,725.00	464,675.00	97.11
44	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,703,200.00	10,238,525.00	464,675.00	95.66
45	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,376,200.00	5,376,200.00		100
46	<b>81835 - СУРГАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ</b>					
46	<b>1220</b>	Тусламжийн орлого	134,013,200.00	134,013,200.00		100
47	122005	Төсвөөс санхүүжих	134,013,200.00	134,013,200.00		100
48	<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,938,200.00	85,053,970.14	39,884,229.86	68.08
49	210101	Үндсэн цалин	70,104,800.00	59,431,989.95	10,672,810.05	84.78
50	210102	Нэмэгдэл	45,516,800.00	18,556,224.45	26,960,575.55	40.77
51	210104	Урамшуулал	9,316,600.00	7,065,755.74	2,250,844.26	75.84
52	<b>2102</b>	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,617,500.00	10,544,884.26	5,072,615.74	67.52
53	210201	Тэтгэврийн даатгал	10,619,800.00	7,514,750.85	3,105,049.15	70.76
54	210202	Тэтгэмжийн даатгал	1,249,500.00	881,757.73	367,742.27	70.57
55	210203	ҮОМШӨ-ний даатгал	999,500.00	692,186.17	307,313.83	69.25
56	210204	Ажилгүйдлийн даатгал	249,900.00	132,399.07	117,500.93	52.98
57	210205	Эрүүл мэндийн даатгал	2,498,800.00	1,323,790.44	1,175,009.56	52.98
58	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>					
59		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,592,131.40	11,592,131.40	-
60		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		75,523,123.62	75,523,123.62	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,552.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1 алдааг залруулж, 7,552.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Тус цэцэрлэгийн биет бус хөрөнгийн дансанд газрын 1мкв гэж бүртгэсэн бөгөөд уг газар нь газар эзэмших эрхийн гэрчилгээнд 3517 мкв гэсэн хэмжээтэй байна.

Биет бус хөрөнгийн данс болон газар эзэмших гэрчилгээнд байгаа хэмжээ нь зөрүүтэй бүртгэлд тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

71.1.1-д “Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.-д “Үнэн зөв байх” зэрэг заалтуудтай нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын явцад залруулах санал тавьж залруулга хийсэн болно.

Аудитаар нийт 7,552.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 4,385.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,166.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### **3.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

### **3.2 Албан шаардлага**

Тус цэцэрлэгийн хүүхдэд ээлтэй орчны зардлаас 4,221.9 мянган төгрөгийн зөөлөн эдлэл, тоос сорогч, хөгжим зэрэг эд зүйлсийг худалдан авахдаа төлөвлөж, тайлагнах баримтын иж бүрдэл дутуу байна. Мөн хөтөлбөр арга хэмжээний зардлын хуваарилалтыг тогтоосон хувиар тооцоогүй 40 хувийг 163.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны А/170 тушаалын хоёр дугаар хавсралтын 2 дахь заалтад “Сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтад баримтлах зарчим, аргачлал”, 2.1.3-д “Төлөвлөх, шийдвэр гаргах, тайлагнах үйл ажиллагаа ил тод байх” 1.9-д “Тухай жилд батлагдсан “Багшийн хөгжлийн зардал”-ын төсвийн 60 хүртэлх хувийг энэ зааврын 1.8.1 д заасан сургалтад, 40 хүртэлх хувийг зааврын 1.8.2-т заасан бусад үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн нь нийцтэй бөгөөд зохистой батламж мэдэгдлийн түвшинд нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн.” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлангийн хугацааны эцэст 883.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авалтаас үүссэн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 -д “Төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид цалин хөлсийг тооцохдоо холбогдох хууль тогтоомжийг баримтлан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцон суутгаагүй асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд тэтгэвэрт гарсан болон групптэй ажиллаж байгаа ажилчдын цалинг зохих код, хувь хэмжээгээр нь авсан ба цалингийн хүснэгтэд 7.8 сард 01 буюу үндсэн энгийн ажилтнаар тооцсон байна. Тус байгууллагын нягтлан бодогч байгууллагын даргын тушаалаар үндсэн ажилтан боловч нийгмийн даатгалын тайланд үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж буй ажилтны хувь хэмжээгээр тооцон 125.4 мянган төгрөгийн зөрүүтэй тооцсон байна.

Энэ нь Сангийн сайд, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайдын 2020 оны 246/А/245 дугаар хавсралт тушаалын "Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код" гэсэн хавсралтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цалин хөлсийг тооцохдоо холбогдох хууль тогтоомжийг баримтлан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

3. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлангийн хугацаанд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 2158.2 мянган төгрөгийг цалин хөлсний зардалд гүйлгэн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 22.6.7.-д "Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", Монгол Улсын Сангийн Сайдын 2021 оны 190-р тушаалыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цалин хөлсийг тооцохдоо холбогдох хууль тогтоомжийг баримтлан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Биет бус хөрөнгөтэй холбоотой	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------

Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлстэй холбоотой	1	2,158.3	-	-	-	-	1	2,158.3	-	-	-	-
Цалин хөлстэй холбоотой	1	125.4					1	125.4				
Авлага, өглөгтэй холбоотой	1	883.2					1	883.2				
Хөтөлбөр арга хэмжээтэй холбоотой	1	4,385.5			1	4,385.5						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>7,645.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>4,385.5</b>	<b>3</b>	<b>3,166.9</b>				

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
2	Төсөл, хөтөлбөр									
3	ЗГТС									
4	ТТЗ									
5	ТЕЗ									
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>				